



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 4171

Мандалговь

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, “Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл”-ийн 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын нутаг дэвсгэр дээр тавигдах “Союз Восток” хий дамжуулах хоолойн барилгын төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай инженерийн иж бүрэн судалгааны ажил гүйцэтгэхийг “Газопровод Союз Восток” ХХК болон түүний туслан гүйцэтгэгч нарт зөвшөөрсүгэй.

2. Инженерийн судалгаа гүйцэтгэхэд шаардлагатай холбогдох баримт материалыг шуурхай гарган өгч, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Цагаандэлгэр сумын Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Батгэрэл) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100417